

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 28 ДУГААР БҮЛЭГТ ЗОХИЦУУЛСАН ХЭЭЛ ХАХУУЛИЙН  
ГЭМТ ХЭРГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**  
(Судалгаа, мэдээлэл)

У. Мөнхбат

**Ерөнхий мэдээлэл**

Албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах хариуцлагын талаар 2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн 263 - 273 дугаар зүйлд тус тус заажээ. Тухайлбал, 268 дугаар зүйлд хээл хахууль авах, 269 дүгээр зүйлд хээл хахууль өгөх, 270 дугаар зүйлд хээл хахууль зуучлах гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлага тусгагдсан байдаг нь энэ төрлийн гэмт хэрэг тухайлбал, авлигын шинжтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн буюу хээл хахууль өгсөн нь, авсан нь ч, мөн зуучилсан нь ч ялгаагүй зохих шийтгэлтэй байх ёстой гэсэн зарчмыг агуулсан байна. Уг хуульд 2008 оны 2 дугаар сард нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө хээл хахууль өгсөн, зуучилсан этгээд энэ тухайгаа сайн дураараа эрх бүхий байгууллагад илчилсэн, мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхөөр зохицуулсан байв.

Харин хээл хахууль авсан этгээд хээл хахууль авснаа мэдэгдсэн, илчилсэн ч эрүүгийн хариуцлагаас эс чөлөөлөгдөхөөр зохицуулжээ. Үүнээс гадна тэдгээр гэмт хэрэгт оногдуулах хариуцлагын хэмжээ ч харилцан адилгүй байгаа нь нийгэмд үзүүлэх хор аюулаас хамааран тогтоосон явдал билээ. Хээл хахууль авах, өгөх болон зуучлах гэмт хэрэгт оногдуулах хариуцлагыг харьцуулан<sup>74</sup> авч үзвэл хээл хахууль авах гэмт хэргийн хувьд хариуцлагын хэмжээ нь хээл хахууль өгөх, зуучлахаасаа их, харин хээл хахууль өгөх гэмт хэргийн хувьд хариуцлагын хэмжээ нь хээл хахууль авахаасаа бага, зуучлахаасаа их байхаар Эрүүгийн хуульд хуульчилсан нь дээрхтэй шууд холбоотой юм.

**1. Монгол Улсын хэмжээнд авлигын шинжтэй гэмт хэргийн тоо ямар учраас буурахгүй байгаа вэ? Хууль нь муу байна уу? эсхүл хуулийн хэрэгжилт муу байна уу?**

Энэ асуудалтай холбогдуулан Авлигатай тэмцэх газараас гаргасан зарим тоон мэдээллийг авч үзэв. Тус газрын Мөрдөн шалгах хэлтэс нь 2007 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж эхэлснээс мөн оныг дуусталхи хугацаанд харъяаллын 86 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас нийт 15 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснийг гэмт хэргийн төрлөөр ангилж үзвэл үйлдлийн давхардсан байдлаар:

- төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг 1;
- төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 4;
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулсан гэмт хэрэг 1;
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлсэн гэмт хэрэг 3;
- хээл хахууль авах гэмт хэрэг 7;
- хээл хахууль өгөх гэмт хэрэг 8;

<sup>74</sup> <http://www.iaac.mn/index.php?cid=22> /2009 оны 9 дүгээр сарын 7 -ны өдрийн байдлаар/

- хээл хахууль зуучлах гэмт хэрэг 1;
- төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг 2 тус тус эзэлж байна.

Харин 2008 оноос 2009 оны хооронд 192 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 58 хэргийг буюу 30.2 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснийг авч үзвэл давхардсан байдлаар:

- төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг 18;
- төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 9;
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулсан гэмт хэрэг 8;
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлсэн гэмт хэрэг 1;
- хээл хахууль авах гэмт хэрэг 29;
- хээл хахууль өгөх гэмт хэрэг 18;
- хээл хахууль зуучлах гэмт хэрэг 5;
- төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг 2 тус тус байна.

Албан тушаалын гэмт хэргийн хувьд тухайн жилд шийдвэрлэгдсэн нийт гэмт хэрэгт эзлэх хувь, шийдвэрлэгдсэн хэргийн тоон үзүүлэлтийг Монгол Улсын Дээд шүүхээс 2002-2008 оны байдлаар гаргасныг нэгтгэн харуулбал:

Албан тушаалын гэмт хэрэг улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн байдал			
Огноо	Шийдвэрлэгдсэн хэргийн тоо	Тухайн жилд нийт хэрэгт эзлэх хувь	Тайлбар
2002	36	0.4%	1986 оны хуулиар 28 гэмт хэрэг, 2002 оны хуулиар 8 гэмт хэрэг
2003	19	0.3%	
2004	19	-	28 хүн шийтгүүлсэн. Үүний дотор хахууль өгсөн 2 гэмт хэрэгт 2 хүн, хахуулийг зуулчилсан гэмт хэрэгт 1 хүн, хахууль авсан гэмт хэрэгт 5 хүн тус бүр шийтгүүлсэн.
2005	23	0.3%	
2006	15	0.3%	
2007	34	0.6%	
2008	25	0.4%	

Дээрх үзүүлэлтээс харахад албан тушаалын гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал нь 2002 оноос 2008 оныг дуусталхи хугацаанд өссөн, буурсан, эсхүл тогтмолжсон **нийтлэг хандлага** ажиглагдахгүй байна. Харин Монгол Улсын Дээд шүүхийн Судалгааны төвөөс албан тушаалын гэмт хэрэг дотроос зөвхөн хээл хахууль авах, өгөх, зуучлах гэмт хэргийн шүүхээр шийдэгдсэн байдлыг тухайлан авч дараахь хүснэгтээр үзүүлбэл хээл хахууль

авах гэмт хэргийн хувьд 2008 онд 2 дахин өссөн, хээл хахууль өгөх гэмт хэргийн хувьд тогтмол буюу 2007 онд, 2008 онд ч 2 гэмт хэрэг шийдэгдсэн байна.

	2007 он		2008 он		2009 оны эхний хагас жилд	
	Хэргийн тоо	Ял шийт-гүүлэгч	Хэргийн тоо	Ял шийт-гүүлэгч	Хэргийн тоо	Ял шийт-гүүлэгч
• Хээл хахууль авах гэмт хэрэг	6	8	13	14	3	6
• Хээл хахууль өгөх гэмт хэрэг	2	3	2	4		1
• Хээл хахууль зуучлах гэмт хэрэг		5				
Нийт	8	16	15	18	3	7

Авлигатай тэмцэх газар, Улсын Дээд шүүхээс гаргасан эдгээр судалгааны үзүүлэлтээс харахад Монгол Улсад авлигын шинжтэй гэмт хэргийн тоо тогтвортой буурахгүй байгааг Эрүүгийн хуулийн зохицуулалт болон уг хуулийн хэрэгжилттэй шууд холбон авч үзэж болохгүй юм.

**2. Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбарыг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсноор нийгэмд ажиглагдаж байгаа зэрэг ба сөрөг тал юу вэ? Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбар хүчингүй болсноор авлигын хэрэг илрүүлэлтэд хэрхэн нөлөөлсөн бэ?**

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн даргатай уулзаж, энэ талаар асуухад тухайн тайлбарыг хүчингүй болгосон нь энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт цаашид буурах шалтгаан болохыг дурдаж байсан. Өмнө дурдсанаар Мөрдөн шалгах хэлтэс нь 2007 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс 15 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснээс хээл хахууль авах гэмт хэрэг 7, хээл хахууль өгөх гэмт хэрэг 8, харин 2008 оны тайлант хугацаанд 58 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлснийг авч үзвэл хээл хахууль авах гэмт хэрэг 29, хээл хахууль өгөх гэмт хэрэг 18 байх боловч дурдсан хугацаанд шүүхээр шийдүүлсэн нь хээл хахууль авах гэмт хэргийн хувьд 2, хээл хахууль өгөх гэмт хэргийн хувьд 2 байна.

Гэтэл 2009 оны эхний хагас жилийн байдлаар шүүхэд хээл хахууль авах гэмт хэрэг 3, хээл хахууль өгөх гэмт хэрэг огт шийдвэрлэгдээгүй, харин 1 этгээд өөр гэмт хэрэгт давхар зүйлчлэгдэн шийтгүүлсэн мэдээлэлтэй байна. Эдгээр тоон үзүүлэлтээс Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбар хүчингүй болсноор хээл хахууль авах, өгөх гэмт хэргийн илрүүлэлт, тэдгээрийн шийдвэрлэлтэд нөлөөлсөн хэмээн дүгнэх боломжгүй юм.

**3. Дээрх тайлбарыг ямар үндэслэлээр хүчингүй болгосон бэ?**

Эрүүгийн хууль болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хувийн хэрэг, мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэрэг<sup>75</sup>, тухайн асуудлыг

<sup>75</sup> Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэвийн хэрэг. МУИХ-ын Тамгын газрын архив, Д №6, ХН №1607

хэлэлцсэн УИХ-ын чуулганы хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг судлан үзэв. Засгийн газрын санаачилсан 2002 оны Эрүүгийн хуулийн төслийг хэлэлцэх явцад Цагдаагийн ерөнхий газар<sup>76</sup>-аас ирүүлсэн саналд тусгагдсанаар “хээл хахууль өгсөн этгээд хэргээ сайн дураараа илчилж ирсэн бол гэмт хэргээс чөлөөлөх” тайлбарыг оруулсан байна. Гэвч Эрүүгийн хуульд 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “хээл хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө” гэсэн тайлбарыг хүчингүй болсонд тооцсон байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас боловсруулан 2006 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэхдээ уг төслийн 5 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн “Тайлбар”-ыг хүчингүй болгохоор санаачилжээ. Гэвч Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгад 269 дүгээр зүйлийн “Тайлбар” гэснийг хүчингүй болгох асуудлыг оруулаагүй байна. Тодруулбал, танилцуулгын 2 дахь хэсэг /Эрүүгийн хуулийн тусгай ангийн талаар/-ийн 2, 13, 15-д албан тушаалын гэмт хэрэгт хамааралтай өөрчлөлтүүдэд<sup>77</sup> тусгагдаагүй юм.

Тодруулбал: 15-д “Эрүүгийн хуулийн зарим зүйл, хэсгийн заалт Захиргааны хариуцлагын тухай, ДОХ өвчнөөс урьдчилан сэргийлэх, Хүүхдийн эрхийг хамгаалах, Эрүүл мэндийн, Жагсаал цуглаан хийх журмын, Хувь хүний нууцын, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн, Харилцаа холбооны тухай хуулийн холбогдох заалтаас хэрхэн ялгагдах нь тодорхойгүй байна. Иймд дараахь өөрчлөлтийг хийлээ. 104.1, 104.2, 132.1, 136.1, 181.1, 227.1, 231.1, 242.1-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар, 103.1, 128.1, 167.1, 230.1, 239.1, 240.1, 244.1-ийг хүчингүй болсонд тооцохоор тус тус тусгаж, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 25.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл боловсруулав” гэжээ.

Мөн УИХ-ын гишүүн Ц. Шаравдорж, Р. Эрдэнэбүрэн нарын санаачилсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 269 дүгээр зүйлийн “Тайлбар”-ыг хүчингүй болгох асуудал тусгагдаагүй байна. Улмаар УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос тогтоол гарган, дээрх 2 төслийг нэгтгэх, УИХ-ын чуулганаар хэлэлцэх бэлтгэлийг хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулснаар анхны хэлэлцүүлэгт оруулах саналын томъёоллыг гаргажээ.

Дээрх асуудалтай холбоотойгоор дараахь баримт бичигтэй танилцлаа:

1. 2007 оны 1 дүгээр сарын 3, 9-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл /Д №6, ХН №1421/;
2. 2007 оны 5 дугаар сарын 22, 23, 29-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл /Д №6, ХН №1422 /;
3. 2008 оны 1 дүгээр сарын 9, 30, 31-ний өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл /Д №6, ХН №1779 /
4. Монгол Улсын Их Хурлын 2007 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 20-ны өдөр (Пүрэв гараг)-ийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл;
5. Монгол Улсын Их Хурлын 2007 оны намрын ээлжит чуулганы 2008 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр (Баасан гараг) -ийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл;

<sup>76</sup> Эрүүгийн хууль болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хувийн хэрэг. I боть. МУИХ-ын Тамгын газрын архив. Д №5, ХН №727

<sup>77</sup> Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэвийн хэрэг. МУИХ-ын Тамгын газрын архив, Д №6, ХН №1607, 18-24 дэх тал

6. Монгол Улсын Их Хурлын 2007 оны намрын ээлжит чуулганы 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдөр (Баасан гараг) -ийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл.

Дээрхээс харахад Засгийн газраас 2006 оны 9 дүгээр сарын 12-нд, мөн УИХ-ын гишүүн Ц.Шаравдорж, Р.Эрдэнэбүрэн нараас 2007 оны 1 дүгээр сарын 2, 2007 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр тус тус УИХ-д өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг 2006 оны 12 дугаар сарын 14, 2007 оны 1 дүгээр сарын 4, 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн ба Хууль зүйн байнгын хороо 2007 оны 1 дүгээр сарын 9, 2007 оны 5 дугаар сарын 22, 23, 29, 2008 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулжээ. Хэлэлцүүлгээр:

- 2007 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд гишүүд хээл хахууль өгөх, авахыг хэвээр нь үлдээх тухай ярисан боловч шийдэлд хүрсэнгүй, хойшлуулсан байна. /Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлтэй холбоотойгоор/- 59,60 дахь тал;
- 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн ХЗБХ-ны хуралдааны тэмдэглэлд 43 дахь санал буюу төслийн 5 дугаар зүйлийн талаар хэлэлцсэнийг сийрүүлжээ. 63 дахь талд төслийн 5 дугаар зүйлийн 269 дүгээр зүйлийн “Тайлбар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжиж байгаа эсэхээр нь санал хураажээ. /73-78 дахь талд/

#### **4. Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбар хүчингүй болсонд ямар байр суурьтай байдаг вэ?**

Хэд хэдэн байгууллага, хувь хүнээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар судалгаа, санал, зөвлөмжөө ирүүлсэн ба тэдгээрийн зарим нь Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбарыг хүчингүй болгох эсэх тухай ямар ч санал ирүүлээгүй, тэр талаар дурдаагүй байдаг. Тухайлбал, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба, Гаалийн ерөнхий газар, Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газар, Монгол банк, Монголын шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр, Монголын сонинуудын холбоо, Монголын эмнести интернэшнл байгууллага, 2 иргэн саналаа ирүүлжээ.

Харин 2 байгууллагаас 269 дүгээр зүйлийн “тайлбар”-тай холбоотой санал, судалгааг ажлын хэсэгт ирүүлсний нэг нь Ерөнхийлөгчийн Тамгын газар, нөгөө нь Авлигатай тэмцэх газар байна. Ерөнхийлөгчийн Тамгын газраас ирүүлсэн Монгол Улсын олон улсын гэрээ болон Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаанд<sup>78</sup> Эрүүгийн хуулийн 268, 269 дүгээр зүйлийг Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц<sup>79</sup>-ын 15, 16 дугаар зүйлтэй харьцуулсан байх бөгөөд “хээл хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх” тухай тайлбарыг олон улсын гэрээтэй уялдуулахдаа өөрчлөх, хүчингүй болгох биш, харин хэвээр нь байлгах агуулгатай саналыг уламжилжээ.

Мөн Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн саналдаа “Эцэст нь хээл хахууль өгөх гэмт хэргийн буюу 269 дүгээр зүйлийн тайлбарыг хэвээр үлдээх нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, түүнтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой тул хэвээр үлдээх саналтай байна”<sup>80</sup>

<sup>78</sup> Энэхүү судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны сектор хийсэн.

<sup>79</sup> Төрийн мэдээлэл эмхтгэл. 2005 он, №43(424), 855-888 дахь тал

<sup>80</sup> Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэвийн хэрэг. МУИХ-ын Тамгын

гэж тодорхой тусгасан байна. Дээр дурдсанаар Авлигатай тэмцэх газар Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн тайлбарыг хэвээр үлдээх саналтай байгаагаа илэрхийлсэн байна.

**5. Эрүүгийн хуулийн хээл хахуультай холбоотой зүйл, заалтыг боловсронгуй болгох тал дээр олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээд болон иргэдээс ирүүлсэн санал, зөвлөмж, дүгнэлт байдаг эсэх?**

Асуултад дурдсанаар зөвхөн хээл хахуультай холбоотой зүйл, заалтыг боловсронгуй болгох талаар ирүүлсэн дүгнэлт, санал, зөвлөмжийг дараахь баримт бичиг, судалгаанаас түүвэрлэн авч Хавсралтаар гаргав. Үүнд:

1. Эрүүгийн хууль болон хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хувийн хэрэг. I боть. МУИХ-ын Тамгын газрын архив. Д №5, ХН №727;
2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэвийн хэрэг. МУИХ-ын Тамгын газрын архив, Д №6, ХН №1607;
3. Монгол Улс дахь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн захиалгаар хийсэн “Монгол Улс дахь авлигалын байдалд хийсэн үнэлгээ” судалгааны тайлан /2005 он/;
4. Авлигатай тэмцэх газраас 2008 онд хийсэн “Авлигын ерөнхий төлөв байдлын судалгааны дүн”;
5. Транспэрэнси Интернэшнлийн (ТИ) 2009 оны Дэлхий Нийтийн Авлигын Хэмжүүр (Барометрийн судалгаа) нь авлигын тухай иргэдийн ерөнхий ойлголт болон хээл хахууль өгч, авч буй байдлын талаарх олон нийтийн төсөөллийг судалсан судалгаа;
6. УИХ-ын номын сангаас “Лобби, авлигын сэдвээр өдөр тутмын сонинд нийтлэгдсэн нийтлэлийн түүвэр” /2001.1.24-2005.5.6/, Боть 1, 2008 он-106;
7. УИХ-ын номын сангаас “Лобби, авлигын сэдвээр өдөр тутмын сонинд нийтлэгдсэн нийтлэлийн түүвэр” /2005.5.10-2005.11.3/, Боть 2, 2008 он-132;
8. УИХ-ын номын сангаас “Лобби, авлигын сэдвээр өдөр тутмын сонинд нийтлэгдсэн нийтлэлийн түүвэр” /2005.11.3-2006.4.26/, Боть 3, 2008 он-135;
9. УИХ-ын номын сангаас “Лобби, авлигын сэдвээр өдөр тутмын сонинд нийтлэгдсэн нийтлэлийн түүвэр” /2006.4.26-2008.4.30/, Боть 4, 2008 он-92.

\* \* \*



**Хавсралт 1**

- Эрүүгийн хууль дахь хээл хахууль авах, өгөх, зуучлах гэмт хэрэгт оногдуулах хариуцлагын хэмжээний харьцуулалт

268 дугаар зүйл. Хээл хахууль авах	269 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх	270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах	Тайлбар
268.1.Албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл <b>таван жил хүртэл хугацаагаар хорих ял</b> шийтгэнэ.	269.1.Албан тушаалтанд өөрөө буюу бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл <b>гурван жил хүртэл хугацаагаар хорих ял</b> шийтгэнэ.	270.1.Хээл хахууль өгч авахад зуучилсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл <b>нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял</b> шийтгэнэ.	Эндээс харахад хээл хахууль авах нь хээл хахууль өгөх, зуучлахаасаа хариуцлагын хэмжээ нь их байгаа бөгөөд нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнээс хамааран 268.1., 269.1.-д заасан гэмт хэрэг нь “хүндэвтэр”, 270.1.-д заасан гэмт хэрэг нь “хөнгөн” гэсэн ангилалд багтаж байна.
<ul style="list-style-type: none"> <li>- Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах</li> <li>- хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</li> <li>- таван жил хүртэл хугацаагаар хорих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</li> <li>- гурван жил хүртэл хугацаагаар хорих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох</li> <li>- нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах</li> </ul>	



268.2.Энэ хэргийг хясан боогдуулах замаар, эсхүл давтан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хээл хахууль авсан бол эд хөрөнгийг хурааж, <b>таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих</b> ял шийтгэнэ.	269.2.Энэ хэргийг давтан, эсхүл хээл хахуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол <b>таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих</b> ял шийтгэнэ.	270.2.Энэ хэргийг давтан, эсхүл хээл хахуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд, түүнчлэн албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Харин дээрх гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн тохиолдолд гэмт хэргийн ангилал өөрчлөгдөх буюу 268.1., 268.2.-т заасан гэмт хэрэг “хүнд”, 270.2.-д заасан гэмт хэрэг нь “хүндэвтэр” гэмт хэрэг болно.
<ul style="list-style-type: none"> <li>- Эд хөрөнгийг хураах</li> <li>- Таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасах</li> <li>• Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,</li> <li>• таван жил хүртэл хугацаагаар хорих</li> </ul>	
	Тайлбар: Хээл хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө. /Энэхүү тайлбарыг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу хүчингүй болсонд тооцсон./	Тайлбар: Хээл хахууль зуучилсан этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.	Авлигын шинжтэй гэмт хэрэг илрэх нь ховор байдаг бөгөөд энэ утгаараа эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх явдал нь тухайн гэмт хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой.

\*\*\*



**Хавсралт 2.**

- Эрүүгийн хуулийн хээл хахуультай холбоотой зохицуулалтын талаархи байгууллага, иргэдийн санал, зөвлөмжийн түүвэр

Субъект	Санал, зөвлөмж
<b>2008 оны 2 дугаар сарын 1 -ний өдөр батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлт, санал, зөвлөмж</b>	
Ерөнхийлөгчийн тамгын газраас ирүүлсэн	<p>Судалгаагаар Эрүүгийн хуулийн 268, 269 дүгээр зүйлийг Авлигын эсрэг конвенцын 15, 16 дугаар зүйлтэй харьцуулсан.</p> <p>Монгол Улсын Эрүүгийн хуулийн төрийн албан хаагч хээл хахууль авах, түүнд хээл хахууль өгөх тухай зүйлийн “албан тушаалтан” гэсэн субъектын хүрээг тодотгож, үүнд гадаад улсын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчийг хамруулах шаардлагатай. Ингэхдээ гадаад улсын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан хаагчид хэнийг хамруулахыг нарийвчлан тодорхойлох.</p> <p>Авлигын эсрэг конвенцын 20 дугаар зүйлд “Хууль бусаар баяжих” талаархи зохицуулалт тусгагдсан ба Монгол Улсын Эрүүгийн хуульд ийм агуулгатай заалт байхгүй.</p> <p>Монгол Улс олон улсын гэрээний энэхүү хэм хэмжээг Эрүүгийн хуульдаа тусгалгүй Үндсэн хуульд заасан “олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх” үүргээ зөрчиж байна. Иймээс Монгол Улсын Эрүүгийн хуулийн “Албан тушаалын гэмт хэрэг” гэсэн бүлэгт конвенцын заалтын агуулгаар “Хууль бусаар баяжих” гэмт хэргийг нэмж хуульчлах.</p>
Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба	<p>Одоогийн үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэгт заасан албан тушаалын гэмт хэргийн 263, 264 дүгээр зүйл, 272.1 дэх хэсэгт зөвхөн хохирол учруулсан тохиолдолд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бий болгохоор хуульчлагдсан тул гэмтлийг үндэслэн хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээр зүйлчилж байгаа ч гэсэн энэ нь хууль хэрэглэх хүрээнд ихээхэн бэрхшээл учруулж байна. Зарим тохиолдолд гэм буруутай албан тушаалтан ямар ч хариуцлага хүлээхгүй байх нөхцлийг бий болгож байна.</p> <p>Иймд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263, 264 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн диспозицид хохирлоос гадна “бага бус гэм хор”, “хүнд хор уршиг” учруулсан байхаар нэмэлт, өөрчлөлт оруулах. Мөн Эрүүгийн хуулийн 263, 264 дүгээр зүйлд заасан “Төрийн албан тушаалтан” гэдэгт хамаарах тайлбарыг хүчингүй болгох.</p> <p>Монгол Улс Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нэгдсэн орсон төдийгүй УИХ-аас Авлигатай тэмцэх тухай хуулийг батлан гаргаад байна. Төрийн албан тушаалтан авлигад автсан гэх үндэслэлтэй эсэх нь тодорхойгүй хардлага газар авч байна. Үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хуулийн “Албан тушаалын гэмт хэрэг” гэсэн бүлэгт заасан гэмт хэргийн агуулга, бүтцийг НҮБ-ын дээрх конвенц, Авлигатай тэмцэх тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх шаардлага бий. Тухайлбал, “Албан тушаалтан хууль бусаар баяжих” гэсэн зүйл хэсгийг “Албан тушаалын гэмт хэрэг” гэсэн бүлэгт шинээр хуульчлах нь авлигатай хийх тэмцлийн үр нөлөөг дээшлүүлэх, нийгмийн сэтгэл зүй дэх хардлагын хөөрөгдлийг таслан зогсооход ач холбогдолтой байж болох юм.</p> <p>Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр заасан үндэслэл бүхий хэргүүд болон мөн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг үйлдсэн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн, мэдэгдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр хуульчлагдсан хэрэг /Эрүүгийн хуулийн 269, 270 дугаар зүйл гэх мэт/-ийн сэжигтэн, яллагдагчийн үйлдлийг мөрдөн байцаалтын шатнаас хялбаршуулан шийдвэрлэх журмыг хуульчлан тогтоох.</p>

Монгол Улсын Ерөнхий прокурорын газар	<p>Эрүүгийн хуулийн 263, 264 дүгээр зүйлүүдийн диспозицид хохирлоос гадна “гэм хор”, “хүнд хор уршиг” учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр нэмэлт оруулах шаардлагатай байна. учир нь төрийн албан хаагч албаны эрх мэдэл, албан тушаалынхаа байдлыг буруугаар ашиглан бусдын амь бие, эрүүл мэндэд халдан гэмтэл учруулсан хэргүүдийг албан тушаалын эсрэг гэмт хэргээр бус, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээр зүйлчлэгдэж байгаа буруу практик тогтоод байна.</p>
Монголын шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр / USAID/	<p>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан “Авлигын гэмт хэргийн ойлголт” гэх 263<sup>1</sup> дүгээр зүйлийн үг хэллэг нь Эрүүгийн хуулийн 268, 269 дүгээр зүйлийн үг хэллэгтэй давхцаж байна. Авлигын хэргээр эрүүгийн хариуцлагад татах бүх нөхцөл байдлыг бүрэн тусгахын тулд энэ бүлгийг бүхэлд нь эргэж харах /дахин хянах/ шаардлагатай. Энэ хуульд албан тушаалтан ашиг хонжоо олох зорилгогүйгээр эрх мэдлээ хэтрүүлж, урвуулан ашиглаж /цагдаагийн албан хаагч хүч хэтрүүлэн хэрэглэх гэх зэрэг/ бусдад хохирол учруулсан тохиолдолд түүнийг эрүүгийн хариуцлагад татах заалт огт байхгүй бололтой. Мөн хууль бус үйлдэл, ажиллагаа нь зөвхөн их буюу онц их хэмжээний санхүүгийн хохирол учруулсан тохиолдолд л гэмт хэрэгт тооцогдож байгаа нь зүйд нийцэхгүй, мөн түүнчлэн бага хэмжээний ашиг хонжоо олсон бол авилгын гэмт хэрэг бус өөр төрлийн гэмт хэрэг болох талтай байна. Үүний зэрэгцээ шийтгэлийн төрлүүдийг эргэж харах (дахин хянах) шаардлагатай. Тухайлбал, албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашигласанд 3-6 сарын баривчлах ял шийтгэж, хээл хахууль авсанд 5 жил хүртэл хорих ял шийтгэж байна.</p> <p>Мөн торгуулийн хэмжээг орлогын хэмжээгээр бус хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоож байгаа нь өндөр орлоготой хүмүүст хөнгөн, харин орлогогүй буюу бага орлоготой хүмүүст илүү хатуу шийтгэл оногдуулж байна гэсэн үг. Энэ нь Эрүүгийн хуулийн нийт зүйл, заалтад хамааралтай.</p> <p>Мөн бизнесийн хүрээн дэх авилгын гэмт хэргийн зохицуулалт байхгүй бололтой.</p> <p>Мөнгө угаах гэдэг нь дийлэнх улс оронд хүнд, онц хүнд, зарим төрлийн (ашиг олох зорилготой) хүндэвтэр (хар тамхи, мансууруулах бодис худалдаалах, хууль бус мөрийтэй тоглоом тоглох, зохион байгуулах гэх зэрэг) гэмт хэрэг үйлдэн олж авсан эд хөрөнгийг гүйлгээнд оруулсан гэмт хэрэг юм. Мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаахад бэрхшээлтэй тул бага хэмжээний мөнгө, жижиг хэргийн хойноос хөөцөлдөх нь үр ашиггүйгээс гадна олон нийтийн эрх ашигт нийцэхгүй. Үүнийг тусгах шаардлагатай болов уу.</p> <p>Үүнээс гадна бусад орны мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжид байдаг, нэн ялангуяа хууль бус болон мөнгө угааж олсон эд хөрөнгийг илрүүлэх ажиллагаанд саад учруулахгүй байх тухай бүхий л арга хэмжээг тусгаагүй байна. Түүнчлэн гэмт хэргийн бүрэлдэхүүн нь илт хууль бусаар олсон эд хөрөнгийг нуун далдлахын зэрэгцээ хууль ёсны болгох гэж ойлгогдож байна. Иймээс энэ заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх болно.</p>
Монголбанк	<p>Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийг дараахь байдлаар өөрчлөн найруулах саналтай байна. Ингэхдээ “Хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж эсхүл хууль бусаар олсон эд хөрөнгө гэж сэжиглэх хангалттай үндэслэл байвал түүний эх үүсвэрийг нуун далдалж, хууль ёсны болгох зорилгоор эзэмшсэн, хүлээн авсан, ашигласан, шилжүүлсэн, эсхүл нуусан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-ээс 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж өөрчлөх.</p>

<b>Авлигын сэдвээр өдөр тутмын сонингийн нийтлэл, ярилцлагад дэвшүүлсэн санал, зөвлөмж</b>	
“Өнөөдөр” сонин, 2001.11.1 “Авлигатай нийтээрээ тэмцье.” / уулзалт, ярилцлага/	Эрүүгийн хуулийг шинэчлэхдээ авлигын талаархи ойлголтыг дэлхий нийтийн жишигт ойртуулах нь чухал. Авлигад холбогдосон компани, аж ахуйн нэгжид эдийн засгийн томоохон хариуцлага хүлээлгэх механизмыг хуулиар бий болгох нь их ач холбогдолтой. /акадеимч С.Нарангэрэл/
“Өнөөдөр” сонин, 2002.4.23 “Авлигатай тэмцэх арга замууд” / нийтлэл/	Эрүүгийн болон авлигын тухай хуульд авлига өгөгч, авагч, зуучлагч, бусад субъектүүдэд ногдуулах хариуцлагын хэмжээг өөрчлөх, авлигын субъектүүдийн гүйцэтгэх буюу үүргийг зөв оновчто тодорхойлж, түүнд тохирсон арга хэмжээ оногдуулж байх./Д.Чулуунбаатар/
Өдрийн сонин, 2004.12.14 “Хээл хахуулийн хэрэг далд нууцаар үйлдэгддэг учраас тэр бүр шүүхэд ирдэггүй” / ярилцлага/	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд зааснаар албан тушаалын гэмт хэргийн бүлэгт хамаарах хэргүүдэд оногдуулах ял шийтгэлийн хэмжээ хөнгөх биш. Бусад улс оронд ялын хэмжээг өөрчлөх ялангуяа хүндрүүлэх зэрэгт урт хугацааны, өргөн цар хүрээтэй судалгаа, шинжилгээний ажлыг янз бүрийн хэлбэрээр явуулж байж, эрдэмтэд судлаачид олон нийтээр хэлэлцүүлж байж хуулиа өөрчилдөг юм билээ. /УДШ-ийн Судалгааны төвийн захирал П.Цэцгээ/
Өнөөдөр сонин, 2005.8.29 “Засаглалын шинэчлэл ба авилгатай тэмцэх нь” / илтгэл/	Авлигын эсрэг эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр доктор Д.Зүмбэрэлхам авлигын хэргийг илрүүлэх, нотлоход дөхөм үзүүлэх үүднээс авлигын үйлдлүүд нотлогдвол санаа зорилго нь нотлогдсон гэж үзэж гэм буруутайд тооцох, албан ёсны орлогоос хэт давсан хөрөнгийнхөө эх сурвалжийг тайлбарлах үүргийг иргэдэд ногдуулах, өндөр албан тушаалын этгээдийг баривчлах, байцаахад шат дамжлага багатай, чирэгдэлгүй журам тогтоох зэрэг заалтыг холбогдох хуульд тусгах. /МУИС-ийн багш, докторант М.Ганзоригийн илтгэл/
Үнэн сонин. 2005.11.10 “Зөвхөн хээл хахууль авсан хүнийг шийтгэх заалт хуульд оруулья” / Авлигатай нийтээрээ тэмцье хэлэлцүүлэг/	... Хээл хахуулийг 3 жилий дотор арилгах бүрэн боломж байна. Үүнд хуульд зөвхөн хахууль авсан хүнийг шийтгэхээр заалт оруулах хэрэгтэй. Хахууль өгч байгаа хүн бол тухайн үедээ хахууль авагчийн дарамт эрхшээлд орж байгаа хэрэг гэж үзвэл зохино. Тэгээд хахууль өгсөн хүн нь эрт орой хэзээ нэгэн цагт өгсөн хахуулиа эргүүлж авахаар нэхэмжилж болох, хахууль өгснөө мэдээлэх эрхтэй байхаар заалт оруулах хэрэгтэй. тэгвэл хэн ч хахууль авч зүрхлэхгүй... /ХУД-ийн II хорооны иргэн Ц.Гэндэнжамц/



Монголын мэдээ 2007.9.22 “Авлигатай тэмцэхэд улс төрөөс ангид байхыг сануулав”	..Авилгатай тэмцэх газар хууль бусаар баяжих, хөрөнгө орлогын мэдүүлгийг санаатайгаар худал мэдүүлэх, өөртөө болон бусдад давуу байдал бий болгох зэрэг асуудлыг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдүүлэх хүсэлтэй байгаагаа Ерөнхийлөгч /энэ үгийг агуулгаар нь оруулав./-д танилцуулав. /Ерөнхийлөгчийн Хэвлэл, мэдээллийн албанаас мэдээллээ./
--	--



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН